

**2017 ОНЫ 08 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН
УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ**

№	Товч агуулга	Хэрэгжилт
1	<p>Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 02 дугаар Албан даалгаврын хэрэгжилтийг байгууллага тус бүрээр гаргаж танилцуулах./НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд/</p>	<p>1-р зорилтын хүрээнд хийсэн ажил: -НИТХ-ын 2014 оны 221, 222 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн сайн малчин, Нийслэлийн тэргүүний фермер шалгаруулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай -Оны шилдэг хүнс үйлдвэрлэгч хүнсний бүтээгдэхүүн шалгаруулах журам -Шимийн архины үйлдвэрлэлд хяналт тавих журмуудыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж байна.</p> <p align="center">Цаашид хийж гүйцэтгэх арга хэмжээ, төлөвлөгөө</p> <p>1.Иргэдээс санал асуулга авах замаар зайлшгүй өөрчлөх шаардлага гарсан, эрх ашгийг нь ноцтой зөрчиж буй дүрэм журмуудын судалгааг гаргаж судлах 2.Өөрчлөлт оруулж болох эсэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах. 3.Их хэмжээний хөрөнгө зарцуулан хийгдсэн ажлуудын үр дүнг тооцох.</p> <p>2-р зорилтын хүрээнд хийсэн ажил: НОБЕГ-с 4 сарын 22-нд зохион байгуулсан гамшгийн сургалт, үзүүлэх сургуулилтад байгууллагын нийт албан хаагчид идэвхитэй хамрагдсан бөгөөд нийт албан хаагчид гамшигийн үед ажиллах ерөнхий ойлголттой болсон</p> <p align="center">Цаашид хийж гүйцэтгэх арга хэмжээ, төлөвлөгөө</p> <p>1.Гамшгийн үед ажиллах сургуулилтын талаар газрын хэмжээнд албан хаагчдаас сорил авах, давтан сургалт явуулах.</p> <p>3-р зорилтын хүрээнд хийсэн ажил: Байгууллагын албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр Ёс зүйн дүрмийг газрын дарга, орлогч дарга, ёс зүйн хорооны гишүүдээс санал авч боловсруулсан бөгөөд газрын даргын тоот тушаалаар батлуулсан. Зөрчил гаргасан албан хаагчдад арга хэмжээ авч холбогдох байгууллагад мэдээг хүргүүлсэн.</p> <p>Иргэдэд үйлчилгээ үзүүлэх талаар ХХААХҮЯ-аас зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож байгууллагын үйл ажиллагааг иргэдэд танилцуулсан. Цахим хуудсаар газрын дарга, орлогч дарга, хэлтсийн дарга нарын иргэдийг хүлээн авах уулзалт хийх өдрийн хувиар гарган ажиллаж байгаа бөгөөд мэргэжилтнүүд ажлын өдрүүдэд ажлын цагаар шаардлагатай мэдээллүүдийг иргэдэд хүргэн ажиллаж байна.</p> <p align="center">Цаашид хийж гүйцэтгэх арга хэмжээ,</p>

төлөвлөгөө

1. Байгууллагын явуулж буй үйл ажиллагааг иргэдэд таниулах сурталчилах ажлыг эрчимжүүлэх. /цахим сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр/

2. Албан хаагчдын сахилага хариуцлагыг сайжруулах тал дээр анхаарч ажиллах. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын ёс зүйн дүрэм, дотоод журам зэргийн хэрэгжилтийг хангах. 3. Төрийн албан хаагчийн Ёс зүйн талаар сургалт зохион байгуулах.

4-р зорилтын хүрээнд хийсэн ажил:

Цаг бүртгэх төхөөрөмжид нийт албан хаагчид хурууны хээг уншуулан ирсэн явсан цагийг бүртгүүлдэг бөгөөд гадуур ажлаар явсан албан хаагчид гадуур ажлын дэвтэрт явсан ажил үр дүнгийн талаар тэмдэглэн ажиллаж байна.

Цаашид хийж гүйцэтгэх арга хэмжээ,**төлөвлөгөө**

1. Албан хаагчдын нийтийг хамарсан арга хэмжээнд оролцох байдлыг сайжруулах тал дээр анхаарч тухай бүрт нь бүртгэл хөтлөх, удаа дараа олон нийтийн арга хэмжээнд оролцохгүй байгаа албан хаагчдад арга хэмжээ авах сахилгын шийтгэл оногдуулах.

2. Өвчтэй чөлөөтэй, тохиолдолд эмчийн магадлагаа, чөлөөний хуудсаар баталгаажуулж байх, зайлшгүй тохиолдолд энэ тухайгаа утсаар мэдээллэж байх.

5-р зорилтын хүрээнд хийсэн ажил:

Нийтээр тэмдэглэх баяр ёслолын үеэр ажиллах хувиарыг тухай бүрт нь гаргаж ажиллаж байгаа.

Цаашид хийж гүйцэтгэх арга хэмжээ,**төлөвлөгөө**

Нийтээр тэмдэглэх баяр ёслол, амралтын өдрүүд /дараалсан өдрүүдэд/ ажиллах хувиарыг гаргах Мэдээллийн тасралтгүй байдлыг хангах талаар анхаарч ажиллах журам тушаал гаргах.

6-р зорилтын хүрээнд хийсэн ажил:

- Нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Батбаясгалангийн баталсан удирдамжийн дагуу “Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалт MNTR 1:2008” болон холбогдох бусад хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Улаанбаатар хотын Цагдаагийн газар хамтран 2017 оны 02 дугаар сарын 06-13-ны өдрүүдэд хяналт шалгалт хийлээ. Шалгалтад хамрагдсан 21 үйлдвэрийг 1.5 кодтой “Согтууруулах ундааны үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас”-аар үнэлэхэд 1 буюу 4.7 хувь нь их, 5 буюу 23.8 хувь нь дунд, 15 буюу 71.4 хувь нь бага эрсдэлтэйгээр үнэлэгдсэн. Эрсдэлийн үнэлгээгээр их буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 7 аж ахуйн нэгжид улсын байцаагчийн хамтарсан албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан.

- ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн дарга, Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын дарга нарын

		<p>баталсан 2017 оны 01/126 дугаартай удирдамжийн дагуу согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд хяналт, шалгалт хийх ажлын хэсэгт орж ажиллан, 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдрүүдэд нийслэлийн 43, төв аймгийн 4, нийт 47 үйлдвэрт хяналт, шалгалт хийсэн. Шалгалтын дүнг МХЕГ-т хүргүүлсэн.</p>
2	<p>Нийслэлийн хэмжээнд 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд айл, өрх, албан байгууллага өвөлжилтийн дулааллагын аян, урилга өрнүүлэх. /Захирагчийн ажлын алба, нийт байгууллагууд/</p>	<p>Байгууллагын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө гарган зайлшгүй шаардлагатай арга хэмжээг авсан ба холбогдох тариаланч, малчид, фермерүүд, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр санамж зөвлөгөө өгч мөн цаг агаарын урьдчилсан мэдээг цаг тухай бүрт малчид, тариалчдад хүргэн ажиллаж байна.</p>